

“Баянхонгор аймгийн иргэдэд экологийн боловсрол олгох”

төсөл

Монгол Улсын Их Сургуулийн Экологийн боловсролын төвөөс Швейцарийн Хөгжлийн Агентлагийн Тогтвортой Бичил Уурхай Төслийн захиалгаар “Баянхонгор аймгийн иргэдэд экологийн боловсрол олгох” төслийг Баянхонгор аймагт 2012 оны 8 сарын 20-оос 12 сарын 15-ны хооронд хэрэгжүүллээ. Орон нутгийн иргэд, хүүхэд багачуудын байгаль орчин, экологийн мэдлэг боловсрол, хариуцлагыг дээшлүүлэх, Экологийн төвийн менежмент, чадавхийг бэхжүүлэх зорилго бүхий уг төсөл дараах гурван хэсгээс бүрдсэн. Үүнд:

1. Орон нутгийн нөхцөл байдалтай танилцах, сургалтын хэрэгцээ шаардлагыг тодруулах
2. Эрэлтэд нийцсэн сургалт, семинар зохион байгуулах
3. Уул уурхайн хүний эрүүл мэнд болоод байгаль орчинд үзүүлэх нөлөөний талаар гарын авлага, зурагт хуудас боловсруулан хэвлүүлэх, экологийн төвийн концепц боловсруулах

Танилцах үйл ажиллагаа

Орон нутгийн нөхцөл байдалтай танилцах ажлын баг 2012 оны 8 сарын 25-29-ний өдрүүдэд Баянхонгор аймгийн төв болон Баян-Овоо, Бөмбөгөр сумдад томилолтоор ажиллалаа. Уг томилолт дараах зорилготой байв. Үүнд:

- Баянхонгор аймгийн 2 сумын бичил уурхайн орчин нөхцөлтэй танилцах
- Бичил уурхай, байгаль хамгаалалтай холбоотой асуулга авч дүгнэх
- ТБУТ-ийн болон төслийн орон нутгийн байгууллагатай мэдээлэл солилцож, сургалтын агуулга, чиглэлийн талаар ярилцаж тохирох

Орон нутгийн нөхцөл байдал, сургалтын хэрэгцээ шаардлага:

- Уул уурхай эрхлэлт болон байгалийн нөөцийн зохисгүй ашиглалт орон нутгийн байгаль орчны тулгамдсан асуудлын эхэнд зүй ёсоор тавигдаж байна.



Санал асуулгын явц

- Уул уурхайн байгальд үзүүлж буй нүдэнд үзэгдэхүйц сөрөг нөлөөг хэн хүнгүй мэдэх боловч нарийн учир холбоо, ирээдүйд үлдээх үл мөрийн талаар тэр болгон мэдэхгүй байна. Ажлын байрны талаар болон орлогын эх үүсвэр бий болгох өөр арга замын талаар мэдэхийг хүссэн хүсэлт хамгийн олон байв. Мөн өөрт ашигтай ургамлын талаар болон байгалийн зэрлэг амьтан, ургамлын талаар, цаашилбал байгаль орчны тухай болон нөхөн сэргээлтийн талаар мэдэж авахыг хүссэн хүн олон байлаа.
- ХАМО иргэдтэй ярилцаж, асуулга авч явахад тэдний дунд боловсролын ерөнхий түвшин сул, бичгээр өөрийгөө илэрхийлэх, хичээл хүлээж авах чадвар багатай иргэд нэлээд байгаа нь ажиглагдсан тул сургалтын агуулгыг болон сургалт, сурталчилгааны материал боловсруулахдаа үүнийг анхаарч, хэн бүхэнд ойлгомжтой, амьдралд нь ойр жишээнд тулгуурласан агуулгатай боловсруулахыг анхаарах нь чухал санагдлаа.



Бөмбөгөр сумын Ширхэний шороон уурхай,
Баян-Овоо сумын Цагаан цахирын үндсэн орд

Сургалт, семинар

ЭБТ-ийн баг, МУИС-ийн Биологи, Биотехнологийн сургуулийн профессор багш нарын хамт Баянхонгор аймагт 2012 оны 9 сарын 21-28-ны өдрүүдэд ажиллаж “Бичил уул уурхай ба миний орчин” сэдэвт сургалт, семинарыг зохион байгууллаа. Сургалт, семинарыг сумын төвийн иргэдэд экологийн боловсрол олгох болон аймгийн төвд экологийн төвийн менежментийг сайжруулах гэсэн хоёр өөр зорилго, агуулгаар зохион байгуулав.

Ажилласан баг:

Доктор Ц.Батчулуун (БЭЛАС, ЭБТ-ийн захирал)

Доктор Р.Сүнжидмаа (ЭБТ-ийн ахлах мэргэжилтэн)

Магистр Ж.Оюунбилэг (ЭБТ-ийн мэргэжилтэн)

Магистр В.Албрехт (ЭБТ-ийн мэргэжилтэн)

Профессор Х.Тэрбиш (МУИС, ББС-ийн Экологийн тэнхим)

Профессор Д.Суран (МУИС, ББС-ийн Ургамал судлалын тэнхим)

Профессор Н.Баатарбилэг (МУИС, ББС-ийн Ой судлалын тэнхим)

“Бичил уул уурхай ба миний орчин” сургалт

Орон нутгийн иргэд, хүүхэд багачуудын байгаль орчны мэдлэг боловсрол, хариуцлагыг дээшлүүлэх зорилго бүхий “Бичил уул уурхай ба миний орчин” сургалтыг Баянхонгор аймгийн Баян-Овоо, Бөмбөгөр, Галуут, Жаргалант сумдад тус бүр зохион байгуулсан бөгөөд төрийн албан хаагч, ХАМО иргэн, малчид болон сумын төвийн иргэдийн төлөөлөл бүхий насанд хүрэгчдийн бүлэг, ЕБС-ийн 12-оос дээш насны сурагчдын бүлэг гэсэн хоёр ангиллаар зохион байгууллаа.

Сургалтын агуулгыг өмнө хийсэн танилцах ажлын асуулгын үр дүнд тулгуурлан боловсруулав. Асуулгад оролцогчид ажлын байрны талаарх мэдлэг мэдээлэл хамгийн их хэрэгцээтэй байгаа, мөн хүнс тэжээлийн ургамал тариалах талаар болон байгаль орчин, ан амьтан, хээрийн ургамлын талаар, тэрчлэн нөхөн сэргээлт, өвөлжөө, уст цэгийн ашиглалтыг зохицуулах талаар мэдэж авахыг хүсэж буйгаа илэрхийлсэн байсан тул уул уурхайгаас гадна эдгээр сэдэвтэй холбож байгалийн нөөцийн хамтын менежмент, биологийн нөхөн сэргээлт, хүн, байгалийн харилцааны талаар сургалтын агуулгыг боловсруулав. Хүүхдүүдэд зориулан уул уурхай эрхлэхийн сайн болоод муу тал, экологийн үл мөрийн тухай болон экологийн танин мэдэхүйн сэдвээр хөтөлбөр боловсрууллаа.



Сургалтыг МУИС-ийн ББС-ийн профессор багш нар удирдан явуулав

Экологийн төвийн менежментийг сайжруулах семинар

Аймгийн төвд зохион байгуулсан Экологийн төвийн менежмент, чадавхийг бэхжүүлж, байнгын ажиллагаатай болгох зорилго бүхий “Экологийн төвийн менежментийг сайжруулах” сэдэвт семинарыг 2012 оны 9 сарын 26-27-ны өдрүүдэд Баянхонгор аймгийн төвд зохион байгуулав. Семинарт Баян-Овоо, Бөмбөгөр, Галуут, Жаргалант сумдаас сонгогдсон төлөөлөгчдөөс гадна Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Боловсрол, соёлын газар, Тусгай хамгаалалттай газрын мэргэжилтэн, ажилтнууд, мөн ЕБС-ийн багш нарын төлөөлөл нийт 27 хүн оролцов.





Танин мэдэхүйн сургалтыг үзүүлэн материал ашигласан,
хүүхдийн оролцоонд тулгуурласан хэлбэрээр зохион байгууллаа

Төслийн үр дүн

Төслийн хүрээнд зохион байгуулсан сургалт, семинарын болон сургалтын дараах үйл ажиллагааны үр дүнг дараах байдлаар товчлон дүгнэж байна. Үүнд:

- Байгаль, экологийн мэдлэг боловсрол олгох сургалтанд Баян-Овоо, Бөмбөгөр, Галуут, Жаргалант сумын нийт 275 хүн хамрагдав. Сургалтанд төрийн албан хаагч, ХАМО иргэн, малчид болон сумын төвийн иргэдийн төлөөлөл болсон 175 иргэн, мөн 12-оос дээш насны 100 сурагч хамрагдлаа.
- Сургалтанд хамрагдсан хүүхдүүдийн сургалтын дараах экологийн мэдлэг, сургалтын өмнөх үеэс 2-2,7 дахин нэмэгдсэн байна. Ерөнхий мэдлэгийн түвшин болон хүлээж авах чадвар сул байсан Баян-Овоо сумын хүүхдүүдийн мэдлэг сургалтын агуулгын 10%-д байснаас сургалтын дараа 27% болж нэмэгдсэн бол, ерөнхий мэдлэг сайтай Жаргалант сумын хүүхдүүдийн хувьд энэ тоо 21%-аас 57% болж өсчээ.
- Экологийн төвийн дэргэд Аймгийн Засаг даргын ивээл дор Эко зөвлөл байгуулагдаж, Аймгийн засаг даргын захирамж гарсан нь энэ ажилд орон нутгийн удирдлага, төрийн албаны анхаарлыг татсан чухал ажил болов.
- Экологийн төвийн 2013 оны төлөвлөгөөг семинарт оролцогчид болон зохион байгуулагчид хамтран боловсрууллаа.



Экологийн төвийн менежментийг сайжруулах семинарын явц



Оролцогчид экологийн төвийн хийж болох
ажлыг танилцуулж байгаа нь

- ЭБТ-өөс Экологийн төвийн менежмент, үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн эх үүсвэр, тогтвортой, тасралтгүй үйл ажиллагааг хэрхэн хангах талаар концепц боловсруулан гаргав.
- ЭБТ хүүхдэд болон насанд хүрэгчдэд зориулан “Уул уурхай ба миний орчин” хялбаршуулсан үзүүлэн боловсруулав.
- ЭБТ-өөс “Уул уурхай ба миний нутаг” сэдэвт олон нийтэд зориулсан гарын авлага боловсруулан гаргав.

Экологийн боловсролын төв

2012 оны 12 сар